

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.01.25-2018.02.25/

### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын харьяалалгүй ахмад настнуудыг байгууллагад харьяалуулах, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн шийдвэрээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа 36 байгууллага 176 ахмадад хүндэтгэл үзүүлж, байгууллагад харьяалалгүй 34 ахмадыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамж хүндэтгэлд тус тус хамрууллаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан сар шинийн хүчит 32 бөхийн барилдааныг 2018.02.14-ний өдөр зохион байгууллаа. Хүчит 32 бөх барилдаанаар Говьсүмбэр аймгийн арслан Э.Мөнхбаатар түрүүлж, Говьсүмбэр аймгийн начин Ц.Батжаргал үзүүрлэж, Говьсүмбэр аймгийн арслан Л.Үүрцайх, Өмнөговь аймгийн арслан Б.Сүхбат нар шөвгөрлөө. Сумын нийтийн золголтыг 2018 оны 02-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, сумын “Хүндэт иргэн”-ээр өндөр настан З.Пүрэвдулам, сумын “Хүндэт Өргөмжлөл”-өөр С.Баттөмөр, Ж.Шаравнямбуу, сумын “Аварга малчин”-аар С.Батмэнд, Б.Сүхбаатар, сумын “Алдарт уяач”-аар О.Доржсүх, М.Алтангэрэл, сумын “Мянгат малчин”-аар Д.Бадамцэцэг, А.Гэрэлчулуун, Спортын алдар “Од” медалиар Л.Цэндбаяр, Б.Алтанбаяр нар тус тус шагнууллаа.



Сумын Хамтарсан багийг 2018 оны 02 сарын 09, 14-ний өдрүүдэд зарлан хуралдуулж, шинэ 2 кейс, хуучин 1 кейс дээр холбогдох ажлыг зохион байгуулж байна.

Суманд шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байгаа “Усу коал” ХХК - тай хамтран сумын өрх толгойлсон, ганц бие харж хандах хүнгүй 5 өрхөд 10 шуудай шахмал түлш олгох ажлыг зохион байгууллаа.



### **ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ**

2018 оны 02-р сарын 22-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	7204000	5227000
2.	ЗДТГ	55698400	47317000

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	59505200	52097422
2.	Соёлын төв	10930700	10410900
3.	3-р сургууль	117639000	113139000
4.	3-р цэцэрлэг	73634600	68034200

### **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, тайланг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулан аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2018 оны 02-р сарын 08-нд зохион байгуулж сумын “Аварга малчин”-аар С.Батмэнд, Б.Сүхбаатар, сумын “Алдарт уяач”-аар О.Доржсүх, М.Алтангэрэл нарыг шалгарууллаа. Мөн “Цэргийн хүндэт медаль”-д Ш.Батмөнхийн материалыг хэлэлцэн дээд шатны байгууллагад хүргүүллээ.

Говьсүмбэр аймгийн Прокурорын байгууллагатай хамтран сумын төсвийн байгууллагын дарга, бичиг хэргийн ажилтан болон ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад “Зөрчлийн тухай”, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай”, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтанд 23 албан хаагч хамрагдсан.



Сумын Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/21 тоот захирамжаар “Сар шинийн баяр”-аар 3 хоног ажиллах сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган хуваарийн дагуу 5 албан байгууллагын 10 ажилтан, албан хаагчид байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн хэв журмын байдалд хяналт тавьж ажилласан ба ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**


### **3-Р СУРГУУЛЬ :**

1. Орос хэлний аймгийн аварга шалгаруулах олимпиадад 8б ангийн сурагч А.Светлена Тэргүүн байр, 8б ангийн Г.Эрхэмжаргал 2-р байрыг тус тус эзэлж, Орос хэлний багш С.Эрдэнэчимэг “Шилдэг багш”-ийн өргөмжлөл хүртлээ. Мөн 2018 оны 02 сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан Орос хэлний улсын олимпиадын II даваанд сумын 3-р


сургуулийн 12 дугаар ангийн 18 сурагч оролцсоноос сурагч Г.Сергей, Н.Оролмаа нар тэргүүлж, улсын олимпиадад оролцох эрх авлаа.

2. “Өсвөр үеийн сагсан бөмбөгийн аварга-2018” тэмцээнээс 9а ангийн сурагч Одмаа 2-р байрыг эзэлж, Мөнгөн медаль хүртлээ.

3. Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх зорилгоор 2-р улирлын амралтаар авсан сорилгын дүнг нэг сурагчийн авсан дундаж дүнгээр харуулбал:



Хичээлийн жилийн 2 дугаар улирлын 2 дахь долоо хоногт аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас авсан сорилгын Математикийн хичээлийн сорилгын дүнг харуулбал:



## СОЁЛЫН ТӨВ

Аймгийн хэмжээнд 2-р ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан "Монгол ёс заншил" сэдэвт уралдаанд 3-р сургуулийн сурагчдын баг 2-р байранд шалгарлаа.



## 3-Р ЦЭЦЭРЛЭГ

Тус цэцэрлэг нь Говьсүмбэр аймгийн хэмжээнд туршин хэрэгжүүлж буй Төсөлт тоглоом, STEAM тоглоомыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын багш нарын хэлэлцүүлгийг сумандаа зохион байгуулж бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгүүдэд “нээлттэй” хичээлийг зохион байгууллаа.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн- 58, үүнээс хүүхэд- 26, дотор- 31, халдварт-1
- Амбулаторийн үзлэг – 309
- Урьдчилан сэргийлэх –46
- Дуудлага- 218

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материал, эм тариа хүрэлцээтэй байна.

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд:

1. 2018 оны 01-р сарын 26-ны өдөр 9 жирэмсэн эхэд “Жирэмсний аюултай шинж, жирэмсний дасгал” сэдэвт сургалт зохион байгууллаа.



2018 оны 02 сарын 02-ны өдөр “Миний гэр-аюулгүй орчин” аяны хүрээнд Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх самбарыг байгууллага дээрээ байрлуулан ажиллаж байна. Мөн тус аяны хүрээнд Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх самбарыг “Шивээ-Овоо” ХК-ийн ажилчдын цайны газарт байрлуулан ажилчдад мэдээлэл өгч ажиллалаа.



2. 2018 оны 02-р сарын 07-ны өдөр 3-р сургуулийн ахлах дунд ангийн нийт 249 сурагчдын дунд “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



2018 оны 02-р сарын 08-ны өдөр аймгийн Онцгой байдлын газраас “Ахуйн осол гэмтэл, гамшигаас сэргийлэх” сургалтанд Эрүүл мэндийн төвийн нийт ажилтан албан хаагчид хамрагдсан.



## **ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ**

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2018 оны 02-р сарын 02-ны өдөр зохион байгуулж 4 иргэний өргөдлийг шийдвэрлэн асаргааны мөнгөн тэтгэмжид Д.Энхсүрэн, Д.Дэлгэрэх, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид Ч.Юнрэнсүрэн, У.Тогоо нарыг хамрууллаа.

2018 онд “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээгээр иргэдэд үйлчилэх Хүнсний дэлгүүрийг сумын Засаг даргын 2018 оны 01-р сарын 12-ны өдрийн А/06 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо 2018 оны 01-р сарын 31-ний өдөр сонгон шалгаруулж 2018 оны 02-р сарын 06-ны өдөр “Энх-Оюу дэвжих” ХХК-тай гэрээг байгуулаад байна.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаагүй болон шилжиж ирсэн 14 өрхөөс өргөдөл хүлээн авч программд оруулсан. Хүүхдийн мөнгөний босго оноо тогтоосонтой холбоотойгоор иргэдэд тухай бүр мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Эхийн алдарт 1, 2-р одонтой эхчүүдийн хувийн хэргийг иргэний бүртгэлийн мэдээлэлтэй тулгаж программд хөдөлгөөнийг хийж, 212 эхэд 27800000 төгрөгийг олгосон.

1. Эхийн алдарт 1-р одонтой 66 эхэд 13200000 төгрөг
2. Эхийн алдарт 2-р одонтой 146 эхэд 14600000 төгрөг

Ахмад настаны тухай хуулийн дагуу “Насны хишиг”-ийн тэтгэмж олгох ажлыг зохион байгуулан 93 ахмад настанд 7070000 төгрөгийн тэтгэмжийг олгосон.

1. 65-69 настай – 39 ахмад настанд 1950000 төгрөг
2. 70-79 настай – 44 ахмад настанд 3520000 төгрөг
3. 80-89 настай – 9 ахмад настанд 1350000 төгрөг
4. 90-ээс дээш настай – 1 ахмад настанд 250000 төгрөг

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журмын дагуу 0-3 насны хүүхдээ асарч байгаа иргэнд сар бүр олгох тэтгэмжийг 153 эхэд 7650000 төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгосон.

2018 оны 02-р сарын 01, 12-ны өдрүүдэд сумын ахмад настнуудад шинээр батлагдсан “Ахмад настны тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулан ахмадын зориулалттай амралт, рашаан сувилал, протез, ортопед тусгай хэрэгслийн талаарх мэдээллийг хүргэлээ.



УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг Говьсүмбэр аймгийн 70-аас дээш настай ахмад настнуудыг 2018 оны 02-р сарын 11-ний өдөр Боржигон чуулгад хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Арга



хэмжээнд Шивээговь сумын 70-аас дээш настай 34 ахмад настнуудыг оролцуулан хүндэтгэл үзүүллээ.

Энэ өдөр сумын 1-р багийн ахмад настан Х.Дэчинсүрэн худалдааны үйлчилгээний “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнагдсан.



## УЛСЫН БҮРТГЭЛ

2017 оны 01 дүгээр сарын 19-нөөс 2018 оны 02 дугаар сарын 22-ны байдлаар Иргэний бүртгэлийн үйлчилгээг 96 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 5 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 7 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгосон. Эхний 2 сарын өссөн дүнгээр 10 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг сумын иргэний бүртгэлээс аваад байна.

2-р сард 46 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

## ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 02 САРЫН МЭДЭЭ

	м/ д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэ й	Эмэгтэ й	Бүгд	Эрэгтэ й	Эмэгтэ й
Төрсөн хүүхэд	1	13				13	5	8
Төрсөн эх	2	13				13		8
Бүртгүүлсэн гэр бүл	3	6				6	6	6
Нас баралт	4	4				4	2	2
Цуцалсан гэр бүл	5	0				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	0				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	27				27	13	14
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	13				13	8	5

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2/28/2018

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 02-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	4	10000				
2	Гэрлэлтийн гэрчилгээний үнэ	2500	3	7500				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	7	105000	3300	7	23500	
4	Өөр аймаг шилжин	2500	1	2500	1000	1	1000	

	явсан							
5	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	15	22500	1000	15	15000	
<b>ДҮН</b>		<b>147500</b>			<b>39100</b>			
<b>НИЙТ ДҮН</b>		<b>186600</b>						

### **МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ**

2018 оны 02-р сарын байдлаар хорогдсон малын тоо 264, үүнээс адуу-38, үхэр-27, хонь-79, ямаа-120 байна. 2018 оны 02-р сарын байдлаар төллөсөн мал-70, бойжиж буй төл-64 байна.

Аймгийн Засаг даргын захирамж болон сумын Засаг даргын захирамжаар Хорио цээрийн дэглэмийг цуцалж 1, 2-р постыг 2018 оны 02-р сарын 03-нд, 3-р постыг 2018 оны 02-р сарын 09-ний өдөр татан буулгалаа.

### **БАЙГАЛЬ ОРЧИН**

Сумын Засаг даргын 2018 оны А/18 тоот захирамжаар 2018 оны бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах хуваарь болон байгууллагуудын цэвэрлэгээ хийх талбайн хуваарийг баталж албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Уг хуваарийн дагуу 02-р сарын 12-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 23 албан байгууллага, аж ахуйн нэгжийн 313 иргэн хамрагдаж 53м<sup>3</sup> хог хаягдлыг ачиж хогийн цэгт төвлөрүүлсэн



Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж орон нутгийн орлогод 975.000 төгрөг төвлөрөөд байна.

### **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**

Сумын 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр “Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах ажил”-ын гүйцэтгэгчээр “Илчлэг Шивээ” ОНӨҮГ шалгарч гэрээ байгуулан ахуйн хог хаягдал тээвэрлэх ажлыг гүйцэтгэж эхлээд байна.

Сумын 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 50 сая төгрөгийн хөрөнгөөр Эрүүл мэндийн төвд эхо томографик 4D аппарат худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог сумын Засаг даргын 2018 оны 02-р сарын 22-ны өдрийн А/24 захирамжаар байгуулан хуралдаж тендерийн бичиг баримт боловсруулж батлуулах шатандаа байна.

Сумын 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр Өвс, тэжээлийн фондыг нэмэгдүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын 2018 оны 02-р сарын 13-ны өдрийн А/22 дугаар захирамжаар байгуулж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах шатандаа байна.

Сумын 2018 оны төсөв шинээр батлагдсантай холбогдуулж төлөвлөгөөг шинэчилж сангийн ямаар дахин баталгаажуулсан. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой мэдээ, тайлангуудыг шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

Мэдээ гаргасан: ДАХОХААХМэргэжилтэн

С.Банзрагч